

Агуулга

БҮЛЭГ 1.	ОРШИЛ.....	1
БҮЛЭГ 2.	ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
2.1.	ТАЛБАЙН БАЙРШИЛ.....	2
2.2.	ХААН ХҮНС ХХК-ИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ.....	3
2.2.1.	Төслийн зорилго	7
2.2.2.	Төслийн ач холбогдол	7
2.2.3.	Төслийн талбайн газар ашиглалт.....	7
2.2.4.	Төслийн хүчин чадал, ажиллах горим.....	9
2.2.5.	Түүхий эд, нийлүүлэлт	10
2.2.6.	Техник, тоног төхөөрөмж	11
2.2.7.	Технологийн горим.....	13
2.3.	ДЭД БҮТЭЦ.....	15
БҮЛЭГ 3.	ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	17
3.1.	УУР АМЬСГАЛ.....	17
3.2.	АГААРЫН ЧАНАР	17
3.3.	УСАН ОРЧИН.....	17
3.4.	ХӨРСӨН БҮРХЭВЧ.....	18
3.5.	УРГАМЛАН НӨМРӨГ.....	18
3.6.	АМЬТНЫ АЙМАГ	18
БҮЛЭГ 4.	ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	19
БҮЛЭГ 5.	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	21
5.1.	БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	21
5.2.	ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	21
БҮЛЭГ 6.	СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ 23	
БҮЛЭГ 7.	ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	25
БҮЛЭГ 8.	ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	26
БҮЛЭГ 9.	ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	27
БҮЛЭГ 10.	ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	29
БҮЛЭГ 11.	ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	30
БҮЛЭГ 12.	ТУХАЙН ЖИЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	33
БҮЛЭГ 13.	ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	34
	ХАВСРАЛТ	35

БҮЛЭГ 1. ОРШИЛ

“Хаан хүнс” ХХК-ийн Өмнөговь аймагт хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Мах боловсруулах үйлдвэр”-ийн 2025 оны Байгаль орчны менежментийг төлөвлөгөө (БОМТ)-г тухайн төслийн Байгаль орчны зөвлөх үйлчилгээний мэргэжлийн байгууллага “Нарт гарден” ХХК боловсруулав. БОМТ-г боловсруулахдаа тухайн төслийн БОННУ-ний тайлан, холбогдох бусад бичиг баримт Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А-618 дугаар “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг удирдлага болгон боловсруулав.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн үйл ажиллагааг эхлүүлэх, үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн байгаль орчны үндсэн баримт бичиг болно.

Тухайн жилийн БОМТ нь дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд: Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ (агаарын чанар, гадаргын ба газрын доорх усны нөөц, хөрсөн бүрхэвч, газрын хэвлий, ургамлан нөмрөг, амьтны аймгийг хамгаалах, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээгээр тогтоогдсон арга хэмжээ болон тухайн орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг тусган), нөхөн сэргээх арга хэмжээ (техникийн болон биологийн нөхөн сэргээлт), биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ, түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ, химийн хортой болон аюултай бодисын эрсдэлийг бууруулах арга хэмжээ, хог, хаягдлын менежментийн арга хэмжээ, орон нутгийн захиргаа, аймаг нийслэлийн байгаль орчны газар, мэргэжлийн хяналтын байгууллага, ажлын хэсгийн дүгнэлт, шаардлагаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах үйл ажиллагаа, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр орно.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт төслийн нөлөөлөлд өртөж буй байгаль орчны дор дурдсан бүрдэл хэсгүүдийг заавал тусгаж, бүрдэл хэсэг тус бүрээр хяналт шинжилгээ хийх цэгийн байршил, хэмжилт, дээжлэлт авах үзүүлэлт, тоо, хугацаа, давтамж, зарцуулах зардал, хариуцан гүйцэтгэх этгээд, баримтлах стандарт, аргачлалыг нарийвчлан тусгана. Үүнд: газрын гадарга, хэвлий, агаарын чанар, дуу шуугиан, гадаргын ба газрын доорх ус, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймаг, тухайн төслийн онцлогтой холбогдсон бусад барилга байгууламж орно.

Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж, батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөлөөг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, БОМТ-г үндэслэн жил бүрийн 12 дугаар сард багтаан дараа оны тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулна.

Хөдөө аж ахуй, үйлдвэрийн төслийн хувьд тухайн жилийн БОМТ-г төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн бизнес төлөвлөгөөтэйгөө уялдуулан боловсруулж батлуулна.

Тухайн төсөлд хийсэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, батлагдсан БОМТ-нд үндэслэн боловсруулсан тухайн жилийн БОМТ-г ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага хянан баталснаар төслийн тухайн жилийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх үүснэ.


БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. ТАЛБАЙН БАЙРШИЛ

“Хаан хүнс” ХХК-ийн “Мах боловсруулах үйлдвэр” төсөл нь Өмнөговь аймгийн Даланзадгад сум, 8-р баг, Цагаан булаг 1-23 тоотод байрлана.

Зураг 1.

Талбайн байршил



2.2. ХААН ХҮНС ХХК-ИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

“Хаан Хүнс” ХХК анх 2002 онд бизнесийн үйл ажиллагаагаа эхэлснээс хойш хүнсний үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, хөдөө аж ахуйн чиглэлээр 19 жил тасралтгүй үйл ажиллагаагаа явуулсаар эдүгээ 300 орчим ажилтан, албан хаагчидтайгаар бизнесээ амжилттай явуулж байна. Өнөөдөр салбартаа тэргүүлэгч, хүнсний манлай үйлдвэр болтлоо өргөжиж, орон даяар нийт 2500 гаруй харилцагч нартайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

№	Үзүүлэлтүүд		Тайлбар
1	Аж ахуйн нэгжийн нэр		“Хаан хүнс” ХХК
2	Регистрийн дугаар		2720752
3	Төслийн нэр		“Мах боловсруулах үйлдвэр”
4	Төслийн дугаар		2021/ОБ-13
5	Төслийн байршил	Нийслэл/Аймаг	Өмнөговь
		Сум/Дүүрэг	Даланзадгад
6	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг		УБ хот, СХД, 29-р хороо, “Хаан хүнс” ХХК-ийн байр
7	Утас		70175588

Манай компани нь тэмээний махыг бууз баншны үйлдвэрлэлдээ оруулаад багагүй хугацааг өнгөрүүлж байгаа бөгөөд энэ хүрээнд түүхий эдээ газар дээрээс нь бэлтгэн нийлүүлэх, нийлүүлж байгаа махны чанар стандартыг тогтмол барих, цаашлаад үйлдвэрийнхээ тэмээний махны хэрэгцээг бүрэн хангах зорилгоор Өмнөговь аймаг, Даланзадгад сумын нутагт тэмээний мах боловсруулах үйлдвэр байгуулсан. Энэхүү үйлдвэр нь цаашид бүрэн хүчин чадлаараа ажилласнаар нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх замаар малчид, нийлүүлэгчдийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх юм.

Тус төсөл нь;

1. “Хаан Хүнс” ХХК-ийн үйлдвэрийн гол түүхий эд болох махыг үйлдвэрлэн боловсруулах ариун цэвэр, эрүүл ахуйн стандартыг хангасан “Махны боловсруулах үйлдвэр”-тэй болсноор дотоодын зах зээлд нийлүүлэх “түргэн хөлдөөсөн хүнсний бүтээгдэхүүн (бууз, банш)” –ний үйлдвэрлэлд шаардлагатай чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан тэмээний махаар өөрийн үйлдвэрийн хэрэгцээг хангах,
2. Мах боловсруулах үйлдвэрийг түүхий эдийн нөөцөд нь тулгуурлан орон нутагт байгуулснаар хөдөөгийн хөгжил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих мөн түүнчлэн нэмүү өртгийн сүлжээг бий болгох, малчид, үйлдвэрлэгчид, хэрэглэгчдийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх,
3. Мах боловсруулах үйлдвэрүүдийнхээ тоног төхөөрөмж, шугам, технологийн урсгалыг стандартын дагуу байршуулж HACCP, ISO олон улсын стандарт нэвтрүүлэх. зорилготойгоор үйл ажиллагаагаа эхлүүлээд байна.

Энэхүү зорилгынхоо хүрээнд үйлдвэрээс гарч буй хог хаягдлыг хамгийн боломжит бага түвшинд байлгах, дахин ашиглах боломжтой саарал ус үйлдвэрлэх, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл эрхлэх тэмүүлэлтэй байна.


Зураг 2.



Мах боловсруулах үйлдвэрийн барилга



Зураг 3.

Төслийн дотоод орчин







2.2.1. Төслийн зорилго

“Хаан Хүнс” ХХК -ийн бууз баншны үйлдвэрийн үндсэн түүхий эд “мах”, махны төрөл дотроо “тэмээний мах”-ыг татан төвлөрүүлж, ангилан боловсруулах ариун цэвэр, эрүүл ахуй стандарт, шаардлагад нийцсэн мах боловсруулах төвийг монгол улсын нийт тэмээний 33%-г эзэлдэг Өмнөговь аймагт бий болгохоор төлөвлөгөө тавин ажиллаж байна.

2.2.2. Төслийн ач холбогдол

Үйлдвэрийн аргаар мал төхөөрөх, мах боловсруулах нь олон дамжлага дамжиж эцсийн хэрэглэгчдэд хүрэх тул аюулгүй, эрүүл хүнс үйлдвэрлэх үндсэн арга юм. Нөгөө талаас ажлын байр нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний өртгийг өсгөх, улмаар бүтээгдэхүүн нь зөвхөн дотоод бус, гадаад зах зээлд өрсөлдөх боломжтой болж, боловсруулах үйлдвэрт технологи, арга дадлага, инноваци нэвтэрч, нэр хүнд, ашиг нь нэмэгдэх ач холбогдолтой.

2.2.3. Төслийн талбайн газар ашиглалт

Мах боловсруулах үйлдвэр нь нийт 1000 м² нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах бөгөөд үүнээс 417.4 м² барилгажсан талбай, 582,6 м² сул талбай байна.

Төслийн талбайд үйлдвэрийн барилга, уурын зуухны барилга, хоёр хөлдөөгч, хог хаягдал түр хадгалах цэг, ажилчдын амрах цэг тус тус байна.

Зураг 4. Төслийн талбайн газар ашиглалт



Хүснэгт 2. Барилга, байгууламжийн мэдээлэл

№	Барилга, байгууламж	Талбайн хэмжээ /м²/
1	Үйлдвэрийн барилга	237.7
2	Уурын зуух	31.2
3	Граж	36.5
4	Хөлдөөгч	96
5	Хог хаягдлын цэг	7
6	Ажилчдын амралтын цэг	9
Нийт		417.4

Зураг 5. Үйлдвэрийн план зураг



2.2.4. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ, АЖИЛЛАХ ГОРИМ

Мах боловсруулах үйлдвэр нь ажлын 22 хоногт ажлын 8 цагаар ажиллах ба сард 154, жилд 1848 толгой тэмээний мах бэлтгэн Улаанбаатар хот дахь “Хаан хүнс” ХХК-ийн хүнсний үйлдвэрт нийлүүлнэ. Тус үйлдвэр нь салбарын менежер, чанар шалгагч, малын эмч, нягтлан, нярав, үйлчлэгч, шулагч, ангилагч, савлагч, ачигч гэсэн 16 хүний бүрэлдэхүүнтэй ажиллана.

Хүснэгт 3. Үйлдвэрийн хүчин чадлын тооцоо /тэмээний тоогоор/

Төслийн нэр	Өдөрт	Сард	Жилд	5 жилд
Мах боловсруулах үйлдвэр	7	154	1,848	9,240

Хүснэгт 4. Өмнөговь аймаг дахь мах боловсруулах төвийн хүчин чадал, мах бэлтгэлийн хэрэгцээ

№	Огноо	Жилээр		Сараар	
		тэмээний тоо	кг-аар	тэмээний тоо	кг-аар
1	2021 он	1,848	554,400	154	46,200
2	2022 он	1,848	554,400	154	46,200
3	2023 он	1,848	554,400	154	46,200
4	2024 он	1,848	554,400	154	46,200
5	2025 он	1,848	554,400	154	46,200
	Дүн	9,240	2,772,000	770	231,000

Өмнөговь аймаг дахь үйлдвэр нь өдөрт 7 тэмээ ангилан ялгах хүчин чадалтай тул ажлын 22 хоногт үржүүлэн сарын тэмээний тоо гарсан бөгөөд, дундаж жин нь 300 кг болно.

2.2.5. ТҮҮХИЙ ЭД, НИЙЛҮҮЛЭЛТ

Монгол улсын хэмжээнд тэмээний мах бэлтгэл нь 2015–2019 онуудын дунджаар нийт бэлчээрийн мах бэлтгэлийн 2.23%-г эзэлж байна.

Хүснэгт 5. “Хаан хүнс” ХХК махны хэрэглээ

№	Махны төрөл	Ястай мах /кг/	Цул мах /кг/
1	Хонь	463656	346815
2	Ямаа	282373	208392
3	Тэмээ	637650	464209
	Дүн	1383679	1019415

Хүснэгт 6. Тэмээний махны хэрэглээ

	2015	2016	2017	2018	2019
Тэмээний мах мян.кг	8,200.0	6,500.0	7,100.0	9,700.0	12,500.0
Тэмээний мах	32,800	26,000	28,400	38,800	50,000
Өсөлт/бууралт		-26%	8%	27%	22%

Эх сурвалж: ХХААХҮЯам

Дээрх хүснэгтэд Монгол улсын хэмжээнд Тэмээний махны хэрэглээг харуулсан бөгөөд сүүлийн 3 жилд дунджаар 19% -н өсөлтийг үзүүлсэн байна. Тус үзүүлэлтээс бид тэмээний махны эрэлтийг харж болох юм.

Хүснэгт 7. Түүхий эдийн зах зээлийн потенциал

Үзүүлэлт	Гүйцэтгэл					
	2015	2016	2017	2018	2019	2020
Нийт тэмээний тоо	118,584	130,493	141,232	152,281	157,863	166,800
Тэмээний өсөлтийн хувь	5%	10%	8%	8%	4%	6%
Зүй бус хорогдол	481	244	190	546	410	449
Бойжуулалт	6,870	6,010	20,380	23,260	22,460	28,529
Аж ахуйн дотоодод хэрэглэсэн тоо	3,289	2,935	3,911	4,032	4,115	4,299
Махны чиглэлээр худалдан борлуулсан тоо	4,753	3,549	6,145	7,664	12,943	15,293

Хүснэгт 8. Түүхийн эдийн потенциалын прогноз

Үзүүлэлт	Төлөвлөгөө						
	2021	2022	2023	2024	2025	2026	2027
Нийт тэмээний тоо	178,088	190,141	203,009	216,748	231,417	247,078	263,800
Тэмээний өсөлтийн хувь	7%	7%	7%	7%	7%	7%	7%
Зүй бус хорогдол	479	512	546	583	623	665	710
Бойжуулалт	31,391	34,540	38,004	41,816	46,011	50,626	55,705
Аж ахуйн дотоодод хэрэглэсэн тоо	4,492	4,693	4,903	5,123	5,352	5,592	5,842
Махны чиглэлээр худалдан борлуулсан тоо	15,610	17,794	20,233	22,955	25,990	29,373	33,141

2.2.6. ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Мах боловсруулах үйлдвэрт нийт 16 хүний бүрэлдхүүнтэй үйл ажиллагаа явуулах ба бэлтгэж савласан махыг 2 ширхэг гүн хөлдөөгчид хадгална.

Хүснэгт 9. Ажлын хувцас, хэрэглэл

№	Хувцас, багаж хэрэгсэл	Нийт хэмжээ	Зураг
1	Ажлын хувцас	14 хос	
2	Усны гутал хамгаалалттай	10 хос	
3	Төмөртэй бээлий	4 ширхэг	
4	Хулдаасан хормогч /ус нэвтрэхгүй/	7 ширхэг	
5	Үйлчлэгчийн ажлын хувцас	4 хос	

6	Нярав, Үйлдвэрийн дарга	2 хос	
7	Мусод хутга эрлэгч	4 ширхэг	
8	Төмөр хормогч	4 ширхэг	

Хүснэгт 10. Тоног төхөөрөмжийн мэдээлэл

№	Тоног төхөөрөмж	Тоо, хэмжээ
1	Хөлдөөгч	2
2	Хөргүүр	1
3	Цахилгаан бойлуур	1
4	Камер	15
5	Нам даралтын зуух	1

Хүснэгт 11. Тоног төхөөрөмж


№	Тоног төхөөрөмжийн жагсаалт	Тоо ширэг	Зураг
1	Ам наагч	1	
2	Шулагч хутга герман	4	
3	Гадна тэрэг	1	
4	Дотор тэрэг	1	

5	Ажлын ширээ	2	
6	Гадна хөлдөөгч	2	

2.2.7. ТЕХНОЛОГИЙН ГОРИМ

Үйлдвэрийн мах, махан бүтээгдэхүүн нь өөрийн гэсэн стандарт технологийн горимыг ягштал мөрдөж, олон шат дамжлага дамжин бэлтгэгдэж, эрүүл ахуйн чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүн гэдгээрээ онцлогтой. Тэмээний мах найрлагын хувьд үхрийн махтай төстэй боловч нүүрс ус, чихэрлэгийн зүйл ихтэй учир ходоодонд шингэх нь сайн, сэрүүн чанартай байдаг тул ямаа болон үхрийн махыг хадгалах, хөлдөөх технологи дээр үндэслэн гаргасан. Учир нь тэмээний махны технологийн батлагдсан горим байхгүй болно.

Зураг 6. Үйл ажиллагааны дараалал



Хүснэгт 12. Үйлдвэрийн технологийн горим

№	Шат дамжлага	Технологийн горим
1	Худалдан авах технологи	Малчин өрхийн авчирсан гарал үүсэлтэй гулууз маханд анхан шатны эрүүл ахуйн үзлэг хийж, жинлэн бүртгэл хийж, хүлээн аваад дараагийн шат дамжлага руу шилжүүлнэ.
2	Сэврээлтийн технологи	Түүхий эд буюу /яс, булчин эд, гадар өөхнөөс бүрдэх/ гулууз махыг -4 ⁰ С хүйтэнд сэврээж, халуун махны гадаргуунд тогтсон хүчлийг зайлуулна. Махыг 12-24 цаг сэврээж, зөөлрүүлэх арга техникийг стандартын дагуу гүйцэтгэнэ.
3	Механик цэвэрлэгээ	Сэврээж буй махыг гадна талын хялгас, үсийг арилгах зорилгоор механик цэвэрлэгээ тохирох стандартын дагуу хийнэ.
4	Шулах технологи	Гулууз махыг мөчлөж, араг яснаас салгаж, зориултын саванд хийж дараагийн дамжлаганд хүргэнэ.
5	Ангилах технологи	Захиалагчийн дагуу булчингийн төрөл, бүтээгдэхүүнийг холбох эдийн агууламж/хальс, /, хүнс тэжээлийн чанараар /өөхтэй, өөхгүй, булчин, цээж, хүзүү г.м/ ангилан ялгана.
6	Савлах технологи	Ангилан ялгасан тэмээний махаа стандартын дагуу захиалагчийн захиалсан хэмжээгээр, стандартанд нийцсэн сав баглаа боодлоор савлаж, үйлдвэрлэсэн он, сар, өдөр бүхий шаардлага хангасан шошго дагалдан бэлтгэнэ.
7	Хөлдөөлтийн технологи	Ангилж савласан тэмээний махыг -26 ⁰ С -30 ⁰ С –аас доошгүй температурт гүн хөлдөөж, махны шинэлэг байдлыг борлуулах үе шат хүртэл хадгалах боломжийг хангуулна. Ингэснээр мах харлах, чанараа алдах байдал гарахгүй байх боломжтой.
8	Хадгалах технологи	Мах махан бүтээгдэхүүнийг -18 ⁰ С доошгүй температурт хадгалах стандартыг мөрдүүлнэ.
9	Тээвэрлэлтийн технологи	Эцсийн мах, махан бүтээгдэхүүний тээвэрлэлтийг зориулалтын сав, хэрэгслээр гүйцэтгэж, тээвэрлэлтийн явцад бүтээгдэхүүн гэмтэх, бохирдох, хорогдох байдал гаргахгүй байх стандартыг мөрдүүлнэ.

Махны анхан шатны боловсруулалт

Махны анхан шатны боловсруулалтын хамгийн хялбар арга нь хүйтний боловсруулалтын арга юм. Хүйтний боловсруулалт нь хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний анхдагч шинж чанарыг аль болох бүрэн дүүрэн хадгалах боломж олгоно. Мах, дотор эрхтэн, дайвар түүхий эд, бэлэн бүтээгдэхүүний чанарыг удаан хугацаагаар хэвийн хадгалах зорилгоор тэдгээрийн дулааны хэмийг буулгах ажиллагааг хүйтний боловсруулалт гэнэ. Мал төхөөрсний дараа махыг заавал хөргөх, хөлдөөх, хадгалах гэх мэт хөргөлт хийх шаардлагатай.

Хүснэгт 13. Мах, махан бүтээгдэхүүний боловсруулалтын ангилал

Түүхий эдийн төлөв байдал	Махны гүний хэм (t)
Халуун мах, дайвар түүхий эд	+ 32
Сэврээсэн мах, дайвар түүхий эд (ямар нэгэн хөргөлтгүй орчны нөхцөлд)	+ 8 хэмээс ихгүй
Хөргөсөн мах, дайвар түүхий эд	+ 8 хэмээс ихгүй
сэврээсэн мах, дайвар түүхий эд (ямар нэгэн хөргөлтгүй орчны нөхцөлд)	- 8 хэмээс бага

Мах хөргөх

- Хөргөсөн мах нь хөлдөөсөн махнаас илүү эрэлт хэрэгцээтэй бүтээгдэхүүн болно.
- Халуун махыг хөргөх ажлыг удаан болон хурдавчилсан аргаар нэг ба хоёр шатлалаар явуулна.
- Удаан аргаар хөргөхөд гадаад байдал тухайлбал гулуузын гадаргууд бүхэлд нь хаталтын зузаан хальс үүсдэг. Энэ хальс чийгтэй орчинд хөвсийж хөөх бөгөөд бичил биетэн үржих таатай нөхцөл болдог ба хадгалалтын хугацаа богиносно.
- Хурдан хөргөхөд гадаад байдал, тухайлбал өнгө тод, хаталтын хальс хэвийн байхын зэрэгцээ жингийн алдагдал багасч, хадгалалтын хугацаа уртасна.

Мах хөлдөөх

- Мах хөлдөөж хадгалах нь бусад аргатай харьцуулахад зардал бага, эдийн засгийн хувьд ашигтай учраас өргөн хэрэглэдэг.
- Хөлдөөхөд бичил биетний тоо, идэвхи ихээхэн буурах боловч бүрэн устдаггүй.

Булчин эдэд агуулагдсан ус нь мөс болон хувирч, шингэн хэсэгт ууссан бодисуудын хэмжээ нэмэгдэнэ.

Мал, мах бэлтгэх өртгийн сүлжээний анхдагч малчин өрх нь бэлчээр, отор нүүдэл, хашаа хороо, худаг ус, тэжээлээр хангаж, малаа үржилд оруулж, өсгөж малын эрүүл мэндийг хамгаалж, эмчлэн сувилах зэрэг ажлыг байнга гүйцэтгэж, малаа эргэлтэнд оруулж худалдах, тээвэрлэх, үйлдвэр гулууз махыг хүлээн авч үзлэг шалгалтанд оруулж, хөргөх, хөлдөөх шулах, ангилан боловсруулах савлах, дэлгүүрт хүргэх, экспортод гаргах, хэрэглэгчидэд очих гэсэн өртгийн гинжин сүлжээг үүсгэнэ.

2.3. ДЭД БҮТЭЦ

Цахилгаан эрчим хүч

Даланзадгад хотод байрлах үйлдвэр нь 250кВ төвийн цахилгаан шугамнаас цахилгаан эрчим хүчний хэрэглээгээ авч 100кВт трансформатораар дамжуулан ашиглаж байгаа.

Зам харилцаа

Мах боловсруулах төв хүртэл төв замаас салаад засмал замаар 430 м, шороон замаар 110 м нийт 540 м зайд байрлаж байна.

Дулаан хангамжийн систем

Одоогийн байдлаар үйлдвэрийн дулааны эх үүсвэрийг нам даралтын зуухаар шийдэж шахдаг болон сордог нацоос нэмж суурьлуулсан. Энэ шийдэл нь байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх төлөвтэй тул бид сайжруулах зорилгоор 50-1400 мм-ын голчтой дулаан дамжуулах далд шугам хоолойгоор төвийн шугамтай холбохоор төлөвлөж байна. Зураг 7-д Өмнөговь аймгийн Даланзадгад хотын дулааны шугам сүлжээний зургийг харуулав.

Зураг 7. Дулааны шугам сүлжээ



Цэвэр усны хангамжийн систем

Цэвэр усны хангамжийн систем нь төвийн шугамд холбогдсон бөгөөд үйлдвэрээс төвийн цэвэр усны шугам 40 м зайд байдаг. Даланзадгад хот нь дулааны станцгүй учир манай хэрэглээний халуун усны хэрэгцээнд бойлуур ашиглаж байгаа болно.

Ариутгах татуургын нөхцөл

Даланзадгад хотод байрлах үйлдвэр нь 30 м зайд байрлах бохир зайлуулах шугамд холбогдсон ба цаашид нэмэлт сайжруулалт хийгдэх шаардлагагүй. Даланзадгад хотод байрлах үйлдвэр бүх өрөөг өдөр бүр ариутгаж цэвэрлэдэг.

Харилцаа холбоо

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь хүн ам төвлөрсөн барилгажсан бүсэд байрлах ба үүрэн телефоны бүхий л сүлжээ ашиглах боломжтой бөгөөд үйл ажиллагаандаа дотоод сүлжээгээр барилгын автомат хяналтын систем, дохиолол хамгаалалтын системийг ашиглана.

Агааржуулалтын нөхцөл

Барилгын дотроос сорж гадагшаа үлээдэг 4 сэнстэй агааржуулалтын систем суурьлуулсан.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1. УУР АМЬСГАЛ

Өмнөговь аймгийн нутаг нь цөлөрхөг хээрийн хуурай уур амьсгалтай, агаарын температурын хэлбэлзэл өндөр, хур тунадас багатай зэрэг эх газрын эрс тэс уур амьсгалтай. Сар болон өдрийн агаарын хэмийн өөрчлөлт эрс ялгаатай. Зун нь уртавтар, маш халуун бөгөөд өвөл нь богинохон, хүйтэвтэр байдаг онцлогтой бүс нутаг юм. Тухайн бүс нутгийн хотгор гүдгэр, газрын гадаргын төрх зэргээс хамааран улирлын шинж газар бүрт харилцан адилгүй байдаг. Энэ бүс нутагт жилийн ихэнх хугацаанд буюу дунджаар 219 хоногт нь дулаан байдаг ба үлдсэн 146 хоногт хүйтэн байдаг. Өвөл нь богино, хуурай, хүйтэн мөн салхи ихтэй байдаг ба дунджаар 119 хоног үргэлжилнэ.

3.2. АГААРЫН ЧАНАР

Өмнөговь аймаг нь өвөл, зуны температурын хэлбэлзэл ихтэй, хур тунадас багатай хуурай уур амьсгалтай нутаг бөгөөд сүүлийн жилүүдэд тус аймагт уул уурхайн салбар эрчимтэй хөгжихийн хирээр тоосжилт ихээр бий болж байгаа бөгөөд энэ нь тухайн нутаг дэвсгэрт ажиллаж байгаа уурхайн үйл ажиллагаа, нүүрс тээвэрлэлтийн замуудтай шууд холбоотой гэж үздэг. Мөн сүүлийн жилүүдэд аймгийн нийт нутгаар хур бороо хомс, өвс ургамлын гарц муу байсан нь хөрс ихээр хуурайшиж тоос босох нэг нөхцөл болж байна. Өмнөговь аймагт 12 төрлийн ашигт малтмалын 71 орд, 185 орчим илрэл тэмдэглэгджээ. Үүний дотор стратегийн ач холбогдол бүхий Оюу Толгой зэс молибдений орд, Таван толгой чулуун нүүрсний орд, Нарийн сухайт нүүрсний ордууд байрлаж байна. Одоогоор Даланзадгад суманд агаарын чанарын хэмжилтийг хийгдэггүй тул ойролцоо орших Даланзадгадын агаарын чанарын SO, NO-ийн 2020 оны 12-р сарын хэмжилтийн мэдээг ашиглав.

Даланзадгад сумын 2020 оны 12-р сарын ажиглалтын дүнгээс үзэхэд агаар дахь хүхэрлэг хийн дундаж агууламж 34 мкг/м^3 , хамгийн их утга нь 21-ны 20 цагт 129 мкг/м^3 , азотын давхар ислийн дундаж агууламж 78 мкг/м^3 , хамгийн их утга нь 21-ны 20 цагт 161 мкг/м^3 байсан байна.

3.3. УСАН ОРЧИН

Төслийн талбай орчмын нутаг дэвсгэр нь Төв Азийн гадагш урсгалгүй ай савд, Галба-Өөш-Долоодын говийн сав газарт хамаарах бөгөөд Монгол орны хамгийн гантай дүүргийн нэг юм. Монгол орны газрын доорх усны горимын дагуух гидрогеологийн мужлалаар улирлын хомс тэжээлтэй хэсэгт хамаарагдана.

Төслийн талбай орчмын гидрогеологийн тогтоцыг доор харуулав. Үүнд:

1. Дөрөвдөгчийн ус агуулагч зузаалаг (Q_{IV})
2. Дээд пермийн ус агуулагч бүрдэл (P_{2tb})
3. Дээд карбон-доод пермийн уст бүрдэл (C_3-P_{1ds})
4. Дунд-дээд девоны уст бүрдэл (D_{2-3cs})
5. Доод пермийн субвулкан чулуулгийн ус агуулагч бүрдэл (μP_1)

3.4. ХӨРСӨН БҮРХЭВЧ

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын нутаг дахь “Мах боловсруулах үйлдвэр” төслийн талбай нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалын хувьд Говийн их мужийн Цөлийн бор саарал хөрсний бүс 15-р тойрог буюу Заг Сүүж-Борзонгийн говийн тойрогт багтана (Үндэсний Атлас, 2009).

Тус төсөл хэрэгжих талбай нь ухаа толгод бүхий тэгшивтэр талд байрлаж байна. Энд харьцангуй өндрөөрөө 30-40 метр ухаа гүвээнүүд, тэдгээрийн хооронд орших тэгшивтэр талуудтай бөгөөд үнэмлэхүй дундаж өндөр нь д.т.д 1100-1500 м. Толгодын өвөр болон ар хажуугийн дээд хэсгээр хатуу суурь чулуулаг газрын гадаргад ойр орших бөгөөд чулуурхаг хөрсөнд ургадаг хуурай хээрийн ургамалшил дор сул хөгжилтэй сайр чулуурхаг цөлөрхөг хээрийн бор хөрс тогтворжсон. Түүнээс доош толгодын хажуу руу намсаж бэл рүүгээ дөхөх тусам нунтаг шороон хурдасны зузаан нэмэгдэж цөлөрхөг хээрийн сайр чулуун хучаастай говийн бор хөрстэй болж ирнэ.

Төсөл хэрэгжих талбай орчим Цөлийн бор саарал хөрсний хэвшинж зонхилон тархах бөгөөд төрлийн хэмжээнд ялгарна. Чулуурхаг бор саарал, сайргархаг бор саарал, сайрын бор саарал, сайрын хөрс тархсан байна.

3.5. УРГАМЛАН НӨМРӨГ

Төслийн талбайн гадарга харьцангуй нэг жигд, нам толгод болон тэдгээрийн хоорондын тэгш тал, нам толгодоос уруудсан жижиг сайрууд, гадаргын усны ууршилт явагддаг хэсгүүдээр давсархаг хотгор ба гүний усны илэрц бүхий намссан хэсгүүдээр цөлөрхөг хээрийн ургамалжилтын хэвшинж зонхилно. Төслийн талбай, түүний ойр орчмын нутаг дэвсгэрийн ургамалжилт 70% нь ганд тэсвэртэй цөлийн болон цөлөрхөг хээрийн ургамлууд зонхилно. Ургамлан нөмрөг тачир сийрэг, доройтолд өртсөн байна.

Ургамалжлын зүйлийн бүрэлдэхүүн. Бидний судалгаа ажил гүйцэтгэсэн газар нь цөлийн хээрийн бэлчээр бөгөөд 7 овгийн 16 зүйл ургамал бүртгэгдсэн. Эдгээр ургамал нь амьдралын хэлбэрийн хувьд сөөг-1, сөөгөнцөр-1, заримдаг сөөгөнцөр-2, олон наст өвс-6, ганц ба хоёр наст-6 зүйл ургамал тус тус тэмдэглэгдэв. Судалгаанд хамрагдсан талбайн ургамалжилт.

3.6. АМЬТНЫ АЙМАГ

Тус төслийн талбай орчимд толгод, тэгш хөндий бүхий амьдрах орчин зонхилох ба жижиг хөхтөн амьтад, мөн зарим суурин шувуудын зүйлүүд түгээмэл тохиолдоно. Тухайлбал, хээрийн бор шувуу *Passer montanus*, оронгийн бор шувуу *Passer domesticus*, хон хэрээ *Corvus corax*, хар хэрээ *Corvus corone*, монгол болжмор *Melanicorypha mongolica* зэрэг шувуудын тохиолдоц их, харин жижиг хөхтөн (мэрэгч) амьтдаас шар чичүүл *Meriones meridianus*, Өмнөговийн алагдаага *Allactaga balikunica*, говийн алагдаага *Allactaga bullata*, Сибир алагдаага *Allactaga sibirica*, элсч савагдаахай *Dipus sagitta* зэрэг мэрэгчид түгээмэл тохиолдож байна.

БҮЛЭГ 4. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Энэ бүлэгт төслөөс байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг нөлөөлөлд өртөх орчноор буюу газрын гадарга, уур амьсгал, агаарын чанар, гадаргын болон гүний ус, хөрсөн бүрхэвч, ургамлын аймаг, амьтны аймаг, түүх соёлын дурсгал, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэдийн нийгмийн байдал, эрүүл мэнд зэрэг чиглэлүүдээр авч үзэн тодорхойлж, тэдгээр нөлөөллийн эрчим, цар хүрээг үнэлэн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг тусгасан болно. Нөлөөлөлд өртөх орчны өнөөгийн төлөв байдлыг тодорхойлох байгаль орчны суурь судалгааг төслийн БОТБҮ-ний шатанд хийж гүйцэтгэсэн бөгөөд эдгээр судалгааны үр дүнгүүдийг нөлөөллийн үнэлгээ тус бүрийн эхэнд товч дурдсан болно.

“Мах боловсруулах үйлдвэр” төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчны төлөв байдалд буюу ус, агаар, хөрс, амьтан, ургамал зэрэгт нөлөөлж болох нөлөөллүүдийг тодорхойлж байна.

Агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ

- Одоогийн ашиглаж буй нам даралтын зуухыг халан төвийн бүсийн төвлөрсөн шугам сүлжээнд холбох
- Тээврийн хэрэгслийн янданд шүүлтүүр тавих, төслийн үйл ажиллагаанд ашиглах машины техникийн оношлогоо, тохиргоо, үйлчилгээг тогтмол хийж, ашиглалтын нөхцлийг сайжруулах замаар агаарын бохирдлыг багасгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай
- Ахуйн болон хүнсний хог хаягдал түр хадгалах цэгийг зонхилох салхины доод зүгт 15-20 метрийн зайд байрлуулж, удаан хугацаагаар хураалгүй төвлөрсөн хог хаягдлын цэгт зайлуулж байх.
- Машин, тоног төхөөрөмж, ажлын байрны дотоод орчинд чийгтэй цэвэрлэгээ тогтмол хийх

Усан орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ

- Хэрэглээний усны оролт болон гаралт дээр тоолуур тавьж хэрэглээг хянах, ундны усыг хадгалах, нөөцлөх, хэмнэлттэй зарцуулах, усны бохирдлыг бууруулах боломжийг бүрдүүлж, эдгээр үйл ажиллагаанд тохируулсан төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах
- Хатуу хог хаягдлыг зохих журмын дагуу төвлөрсөн цэгт түр хадгалж, нэгдсэн цэг рүү зөөх
- Хатуу хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх
- Мах боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламж барих

Хөрсөн бүрхэвч, газрын гадаргад үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ

- Эвдрэлтэй тээврийн хэрэгслийг цаг тухайд нь засвар, үйлчилгээнд оруулж байх, хэрэв хөрс шатах, тослох материалаар бохирдсон бол тухай бүрд нь зохих стандартын дагуу ариутгаж, цэвэрлэх
- Технологийн хаягдал тос хадгалах цэгийг хаших, битүүмжлэх. Хатуу хог хаягдлыг түр хадгалах битүүмжлэл сайтай хогийн савуудыг зохимжтой газар байршуулах, битүүмжлэлийг тогтмол шалгаж байх
- Автомашины байнгын зогсоолын талбайг тохижуулах, засварын газрын хашааны дотор, гадна талбайд цэвэрлэгээг тогтмол хийж услаж байх

Ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ

- Үйлдвэрийн ажилчид дур мэдэн зам жим гаргахгүй байх тал дээр анхаарах ба маршрутын дагуу зам гаргах
- Тогтсон цаг хугацаанд төслийн талбайн өнгөн хэсгийн хөрсийг услах
- Үйлдвэрийн ажилчдын хөл хөдөлгөөнөөс шалтгаалан ургамлан нөмрөг талхаглагдахаас сэргийлэх

Амьтны аймагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ

- Авто машины дуут дохиог гэнэтийн ослоос сэргийлэхээс бусад үед өгөхгүй байх, оройны 10 цагаас хойш ямар нэгэн олныг хамарсан дуу чимээ гаргуулахгүй байхба ажлын бус цагаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг багасгах
- Мах, махны хаягдал, яс зэргийг ил задгай хаяхгүй байх, золбин нохойд, зарим зүйлийн шувууд цугларахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах буюу хатуу хог хаягдал түр хадгалах савыг битүүмжлэлтэй, тагтай зориулалтын сав ашиглах.

Нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ

- Ямар нэгэн осол гэмтэл гарсан даруйд хариуцагч компани болон тусламжийн мэдээллийн ажилтанд яаралтай мэдэгдэх
- Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслийг тогтмол өмсөж хэвшүүлэх
- Машин механизмтай ажиллах зааварчилгааг тогтмол өгч байх
- Халдвар хамгааллын дүрэм журмыг тогтмол сахих

БҮЛЭГ 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

БОМТ нь дараах үндсэн 2 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
2. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

5.1. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө /БОХТ/ нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “Хаан хүнс” ХХК-с заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм.

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг холбогдох журам, ерөнхий үнэлгээгээр тавигдсан шаардлагын дагуу урьдчилсан байдлаар тодорхойлж тусгав. Эдгээр зардлууд нь байгаль орчныг хамгаалах ажлын шууд зардлууд бөгөөд түүнтэй холбогдон гарах бусад зураг төслийн буюу туслах чанарын ажлуудын зардал ороогүй болно.

Мөн энэхүү БОХТ-ний ихэнх хэсэг байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөртэй нягт уялдах бөгөөд төслийн хэрэгжилтийн бүхий л хугацааны туршид газрын доорх ус, хөрсний чанар, ургамалжилт, амьтны аймагт гарч байгаа өөрчлөлтүүдийг тухай бүрт нь шинжилж, холбогдох арга хэмжээг жил бүрийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж байх шаардлагатай.

5.2. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Хаан хүнс” ХХК-с явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.

ОХШХ нь БОХТ-тэйгээ нягт уялдсан бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг төсөл хэрэгжүүлэгч хариуцах болно. Төслийн талбай болон үйлдвэрийн дотоод орчинд ОХШХ-д тусгасан хяналт шинжилгээг хийж холбогдох стандарт, нормоос хэтэрсэн тохиолдолд багасгах арга хэмжээ авч ажиллах шаардлагатай.

Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт

1. Төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө техникийн нөхцөл, ажлын зургийн дагуу төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсноор нам даралтын зуухны хэрэглээг зогсоож агаарт учруулах сөрөг нөлөөллийг арилгах
2. Мах боловсруулах үйлдвэрийг зориулалттай цэвэрлэх байгууламж барьж төслийн үйл ажиллагаанаас ялгарах бохир усыг цэвэршүүлэн саарал усыг ногоон байгууламж болон талбайн усалгаа, техникийн цэвэрлэгээнд хэрэглэж цэвэр усны хэрэглээг багасгах.
3. Төслийн талбайн 20%-с доошгүй талбайд мод тарьж ногоон байгууламж бий болгосноор агаар дахь хүчилтөрөгчийг нэмэгдүүлэх, тоосонцорын дэгдэлтийг багасгах
4. Төслийн талбайн гадна зогсоолыг цементлэн тохижуулж хөрсөн бүрхэвч талхлагдах, агаарт тоос дэгдэхээс урьдчилан сэргийлэх

Хүснэгт 14. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал

Д/д	Авах арга хэмжээ	Зардал, төгрөг
1	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	180,000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	900,000
3	Эрсдлийн менежментийн төлөвлөгөө	300,000
4	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	2,100,000
5	Орчны хяналт шинжилгээ	860,000
6	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	-
	Дүн, төгрөг	4,340,000

БҮЛЭГ 6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 15. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нэгж үнэ, төгрөг	Нийт зардал, төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Хууль эрх зүйн шаардлага
Агаарын орчин						
Агаарын бохирдол, тоосжилт үүсэх	Авто тээврийн хэрэгслийг жил бүр үзлэгт хамруулж, агаарын бохирдлын төлбөрийг төлөх, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг цаг тухайд нь хийх	Төсөлд хэрэглэгдэх техникүүдэд	20 000	180 000	2025 онд	Агаарын тухай хууль, MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, MNS 0017-2-3-16:1998 MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ-хэвийн норм, түвшний хэмжээ
	Авто машины дуут дохиог гэнэтийн ослоос сэргийлэхээс бусад үед өгөхгүй байх, оройны 10 цагаас хойш ямар нэгэн олныг хамарсан дуу чимээ гаргуулахгүй байх	Төслийн талбайд	Дотоод төлөвлөгөөгөөр	Дотоод төлөвлөгөөгөөр	2025 онд	
Усны нөөц, чанар						
Усны хэрэглээг хянах	Усны төлбөрийг тогтсон хугацаанд төлөх	Усны нөөцийг зохистой ашиглах	-	-	2025 онд	MNS 13.060.50 Усны чанарын стандарт Усны тухай хууль ЗГ-ын 2009 оны 351 дүгээр тогтоолын хавсралт -Ус ашигласаны төлбөрийн хувь хэмжээ/
Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах	Бага оврын цэвэрлэх байгууламжийн бүрэн бүтэн байдлыг тогтмол хянах		-	-	2025 онд	MNS EN 12255-1 : 2012 Бохир ус цэвэрлэх байгууламж. Байгууламжийн ерөнхий зарчмууд
Хөрс, ургамал, газрын гадарга						

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нэгж үнэ, төгрөг	Нийт зардал, төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Хууль эрх зүйн шаардлага
Төслийн талбайн хөрсөн бүрхэвч талхлагдах	Тээврийн хэрэгслээс шатах, тослох материал асгарахаас сэргийлэх. Асгарсан тохиолдолд түргэн шуурхай сэргийлэх арга хэмжээ авах.	Төслийн талбайд	-	-	2025 онд	
	Төслийн гаднах талбайд бүх нийтийн их цэвэрлэгээг тогтсон хугацаанд тогтмол хийх	Төслийн талбайд	-	-	Төслийн үйл ажиллагааны үед	
Амьтны аймаг						
Төслийн талбай орчмын зэрлэг амьтдыг үргээх цочоох	Автомашинууд зайлшгүй ослоос сэргийлэхээс бусад тохиолдолд дуут дохио өгөхгүй байх	Төслийн талбайд	-	-	2025 онд	
НИЙТ			180 000			

БҮЛЭГ 7. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 16. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Төслийн талбайд элэгдэл, эвдрэлд өртсөн газрыг тохижуулах	Орчны тохижилт	Төслийн талбайн ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэн хайлаас мод тарих	ш	1,800	500	900,000	2025 онд	Ургамал хамгааллын тухай хууль
		Ногоон байгууламжийн арчилгаа тордолгоог тогтмол хийх	м²	-	200 м²	-	2025 онд	
Нийт	900,000							

БҮЛЭГ 8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төслийн талбай нь хотын суурьшлийн бүс нутаг, гэр хороолол байгаа бөгөөд одоогоор түүх, соёлын өв илрээгүй. Тус төслийн барилгын ажлын үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжыг мөрдөн ажиллах шаардлагатай.

БҮЛЭГ 9. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 17. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нэгж үнэ, мян. төг	Нийт зардал, төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Хууль эрх зүйн шаардлага
Гал түймрийн улмаас үйлдвэрийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, галын хор зэргийг тогтсон стандартын дагуу байрлуулж бэлэн байдлыг хангаж ажиллах	Үйлдвэр	100,000	300,000	2025 онд	Галын аюулгүй байдлын тухай хууль
Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Төслийн талбай	-	-	Өдөр бүр, /тогтмол/	Гамшгаас хамгаалах тухай хууль
Ажилчдын эрүүл мэнд,	Цэвэрлэгээ, халдваргүйтгэлийг графикийн дагуу хийдэг, бүртгэл хөтөлдөг, дотоод хяналтын журам боловсруулж мөрдөх, хяналтын ажилтныг томилон ажлын байрны тодорхойлолтод ажил үүргийн хуваарийг нарийн тусгах	Төслийн талбайн эрүүл ахуйн хамгаалалтын бүс	Үйл ажиллагааны хүрээнд		Тогтмол	- Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль - Худалдаа үйлчилгээний байгууллагын ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах журам - ЭМ-ийн сайдын 2017 оны А/145-р тушаал - Мах махан бүтээгдэхүүний эрүүл ахуй аюулгүй байдлын үндсэн шаардлага MNS 5023:2001
	Ажилчдыг ХАБЭА-н сургалтанд хамруулж, тогтсон хугацаанд давтамжтайгаар явуулах	Ажилчдад	Үйл ажиллагааны зардал		Тогтмол	
	Ажиллагсад амны хаалт, ханцуйвч, бээлий, малгай, хормогч хэрэглэж хэвших, халдвар хамгааллын нэг удаагийн хувцас хэрэгслээр хангах	Ажилчдад	Үйл ажиллагааны зардал		Тогтмол	
	Цэвэрлэгээ, халдваргүйтгэлийг графикийн дагуу хийдэг, бүртгэл хөтөлдөг, дотоод хяналтын журам боловсруулж мөрдөх, хяналтын ажилтныг томилон ажлын байрны тодорхойлолтод ажил үүргийн хуваарийг нарийн тусгах	Төслийн талбайн эрүүл ахуйн хамгаалалтын бүс	Үйл ажиллагааны хүрээнд		Тогтмол	
	Ажилчдыг эрүүл мэндийн хугацаат үзлэг, шинжилгээнд хамруулах	Ажилчдад	Гэрээт ажлын дүнгээр		2025 онд	

Химийн бодисын эрсдэлээс урьдчилах сэргийлэх	Химийн бодис асгарч алдагдах, ажиллагсад хордох, бэртэл гэмтэл, галын галын үед бодисыг хураан авах сав, хүрз, хоргүйжүүлэх саармагжуулах бодис урвалж, яаралтай тусламжийн эмийн сан, гал унтраах багаж хэрэгсэл, нөөц бололцоог бэлэн байлгах	Төслийн талбай	Үйл ажиллагааны зардал	2025 онд	
	Химийн бодис хадгалах агуулахыг стандартын дагуу тохижуулах, ашиглах, тогтмол хянах, сайжруулж байх	Хөргөлтийн шингэний агуулах	Үйл ажиллагааны хүрээнд	Тогтмол	
	Үйлдвэрийн хөргөлтийн системд хөргөгч хий ашиглах бөгөөд тухайн бодисын хор аюулын лавлах мэдээлэлд (MSDS) заасны дагуу аюулгүй ажиллагааны дүрэм журам боловсруулах.	Хөлдөөгч болон гүн хөлдөөгч	Үйл ажиллагааны зардал	2025 онд	ЗТБХБСайдын 2010 оны 234р тушаал БНбД31-18-10 Хөргөлтийн систем
Нийт	300,000				

БҮЛЭГ 10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 18. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нэгж үнэ, мян. төг	Нийт зардал, төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Хууль эрх зүйн шаардлага
Хаягдал бохир ус, хатуу хог хаягдлаас үнэрийн бохирдол үүсэх	Хатуу хог хаягдлыг хуванцар, цаас мод, төмөр, шил, дахин ашиглах боломжгүй хаягдал гэх мэтээр ангилан ялгаж хадгалах сав байршуулах	Төслийн талбайд	500,000	500,000	2025 онд	- ДБХ-ийн сайд, БО-ны сайд, ЭМНХ-ын сайдын 1997 оны А/11/05/А18 тоот тушаалын хавсралт - Монгол улсын хог хаягдлын тухай хууль, 4-р бүлэг, 15-р зүйл - Монгол улсын хог хаягдлын тухай хууль - Ахуйн шавж, мэрэгч устгал, халдваргүйтгэлийн үйл ажиллагаанд мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм
	Хатуу хог хаягдлыг тогтмол ачуулах	Төслийн талбайд	150,000	800,000	2025 онд	
Ахуйн шавьж мэрэгч үүрлэх	Ахуйн шавьж мэрэгчийн устгал	Үйлдвэрт	200,000	800,000	2025 онд	
	Дахин боловсруулагдах хог хаягдлыг хоёрдогч түүхий эд авах байгууллага, нэгжид нийлүүлэх	Дахин ашиглагдах хог хаягдал	Үйл ажиллагааны зардал		2025 онд	
	Үүссэн аюултай хог хаягдлаа эрх бүхий байгууллагад, эсхүл тогтоосон тусгай цэгт хүлээлгэн өгөх	Хөргөлтийн шингэн	Үйл ажиллагааны зардал		2025 онд	
	Хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх сургалт хийх	Үйлдвэрийн ажилчдад	Үйл ажиллагааны зардал		2025 онд	
	Аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах	Төслөөс үүсэх хог хаягдал	Гэрээний үнийн дүнгээр		2025 онд	
	Малын гаралтай хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулах	Малын гаралтай хог хаягдал	Үйл ажиллагааны зардал		2025 онд	
Нийт	2,100,000					

БҮЛЭГ 11. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Хаан хүнс” ХХК-ийн үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан чухал баримт бичиг юм.

Үйл ажиллагааны явцад байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасан болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор тогтмол дээжлэлт, сорьц авч байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулиудын дагуу “Хаан хүнс” ХХК нь батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 11 дугаар сарын 1-ний дотор холбогдох төрийн захиргааны төв байгууллага (БОАЖЯ)-д хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Үйл ажиллагаанаас агаар, ус, хөрс, ургамалд үзүүлэх нөлөөллийг илрүүлэх, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт, сөрөг нөлөөллийг бууруулах талаар авсан арга хэмжээний дүнг хянаж шалгах, цаашдын үйл ажиллагааг тодотгох зорилгоор хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

Хүснэгт 19. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
Агаарын чанар					
1.1	Агаарын бохирдлын (NO ₂ , SO ₂ , CO) шинжилгээ хийлгэх	Төслийн талбайд цэг сонгох	Агаарын найрлага:	200 000	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага,
1.2	Ажлны байрны дотоод орчны бохирдолд шинжилгээ хийлгэх		Улиралд нэг удаа	150 000	MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага,
1.3	Агаарын тоосны (TSP, PM ₁₀ , PM _{2.5}) шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх		Тоосны хяналт	100 000	MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
1.4	Ажлын байрны дуу чимээний хэмжилтийг мэргэжлийн байгууллагаар тодорхойлуулж, стандарттай харьцуулах		Жилд 1 удаа	50 000	MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшний хэмжээ Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны агаар дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага. MNS 5010:2001
Хөрсний бохирдол					
2.1	Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент (NO ₃ , P ₂ O ₅ , K ₂ O), хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд, хүнд металлууд, нянгийн бохирдол	Авто зогсоол, түр хогийн цэг, эрүүл газар	Жилд 1 удаа 2 цэгт	Хүнд металл: 75,000 (Ханлаб ХХК-ийн үнэ болно.) Ерөнхий хими физик чанар 25 000 Нянгийн үзүүлэлт 30 000 Нийт: 260,000	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох.

					Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Ургамлын аймаг					
3.1	Ургамлын бичиглэл	Төсөл хэрэгжих орчинд	Жилд 1 удаа	100 000	
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН 5 ЖИЛИЙН НИЙТ ЗАРДЛЫН ДҮН				860,000 төг	

БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Аливаа байгууллагын байгаль орчны асуудлыг хариуцах, удирдан зохион байгуулах бүтэц нь ISO 14001 2004 (MNS 2006) стандартад заасан Байгаль орчны удирдлагын тогтолцоо (БОУТ) бөгөөд үүнд тухайн байгууллагын байгаль орчны бодлогын хүрээнд төлөвлөх-хэрэгжүүлэх-хянах-шийдэх-хуваалцах гэсэн 5 үйл ажиллагаа тасралтгүй хийгдэж байгаль орчны үзүүлэлт байнга сайжирч байх нөхцлийг бүрдүүлдэг байна.

Засварын газрын үйл ажиллагааны явцад байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгээр үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, үйлдвэрийн удирдлага нь төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээг авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна.

Хүснэгт 20. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн өртөг	Зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
1	Ажилчдын байгаль орчинд хандах байдал, тэдгээрийг хайрлан хамгаалах мэдлэг дутмагаас орчныг бохирдуулах, гэмтээх, сүйтгэх	Ажилчидад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт семинарыг зохион байгуулж, хамруулах	Ажилчид	-	-	Тогтмол
2		Аюулгүй ажиллагааны дотоод журам тогтоож, өдөр тутамд мөрдлөг болгон ажиллах	Ажилчид	-	-	Тогтмол
3		Ажилчдыг зориулалтын хувцас хэрэглэлээр хангах	Ажилчид	Үйл ажиллагааны зардалд оруулах		Тогтмол Жилд 1 удаа
4		Байгууллагын нийгмийн хариуцлагын хүрээнд харьяа аймаг сумын удирдлага, иргэдийн нийтийн байгууллага, оршин суугчидтай хамтран ажиллах.	“Хаан хүнс” ХХК	-	-	Жилд 1 удаа
5	БОМТ биелэл/хэрэгжилт болон дараа оны БОМТ тайлан бэлтгэх, тайлагнах, батлуулах		“Хаан хүнс” ХХК	-	2024 оны 11 сарын 1-ний дотор БОАЖЯ-нд хүргүүлэх	Жилд 1 удаа
Нийт				-		

БҮЛЭГ 13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгч жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар Нийслэлийн байгаль орчны газарт тухайн жилийн тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллагад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ. Мөн БОМТ-ний хэрэгжилтийн талаар танилцуулгыг хагас жил тутамд хийнэ.

Хүснэгт 21. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
БОАЖЯ	БОМТ-н жилийн төлөвлөгөө	БОННУ-р тодорхойлсон сөрөг нөлөөллийг бууруулах, зөвлөмж, батлагдсан БОМТ-нд үндэслэн тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах	Жил бүр Эхний улиралд	Төлөвлөгөө батлуулах	БОАЖЯ
БОАЖЯ, Нийслэлийн Байгаль орчны газар	БОМТ-н жилийн тайлан	Төлөвлөгөөний хэрэгжилт, ОХШХ-н хэрэгжилт	Жил бүр 11-р сарын 1-ний дотор	Тайлан хянуулах	БОАЖЯ, НБОГ
БОАЖЯ-ийн сайдын 2019 оны А/618 тоот тушаалын 4.3-т заасны дагуу ажлын хэсгийг тухайн аймаг,	БОМТ-н жилийн төлөвлөгөө, тайлан	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн талаар	Жил бүр 11-р сарын 30-ний дотор	Тайлан хянуулах, дүгнүүлэх (хяналтын хуудас авах)	Аймаг, нийслэлийн ЗДын захирамж
Нөлөөллийнбүсэд оршин суугч, Даланзадгад сумын 8-р хорооны иргэд, багийн засаг дарга, ИНХ	Танилцуулга, илтгэл болон мэдээлэл өгч хурлаар хэлэлцүүлэх	БОМТ-ний хэрэгжилтийн явцыг БО-ны бүрдэл хэсгүүдээр гарган танилцуулах	Жилд 1 удаа	БО-ны хэлтэс, Орон нутагтай харилцах ажилтан	Орон нутгийн ЗДТГ болон төслийн талбайд

ХАВСРАЛТ

1. Төсөл хэрэгжүүлэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээ
2. Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээ
3. Газар эзэмших эрхийн гэрчилгээ, кадастрын зураг
4. Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээ
5. Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт
6. Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн ажлын байрны дүгнэлт
7. Ахуйн хортон шавьж устгал, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажил гүйцэтгэх гэрээ
8. Малын гаралтай түүхий эд бэлтгэн нийлүүлэх гэрээ
9. Хөргөлтийн тоног төхөөрөмж нийлүүлэлт, угсралт хийх гэрээ
10. ХЗАА-тай “Хог хаягдал тээвэрлэх гэрээ”
11. Цэвэр усаар хангах, бохир ус зайлуулах гэрээ
12. Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ